



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 814,191,031.00 (найман зуун арван дөрвөн сая нэг зуун ерэн нэгэн мянга гучин нэг) төгрөгийн үнэ бүхий Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Дэлгэрмөрөн өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Цэнд-Аюуш нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын хөрөнгөд бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;


2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001346

11-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 04 дүгээр сарын 18-ны/ний өдрийн  
18 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР-БАРЬСАН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Эмнэлгийн барилга, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, бага төвөгшилтэй ангилалын, зорьгүй, 1 давхар, тэнхлэгээрээ 21.0м*12.0м, барилга	814,191,031.00	2023.12.19	ББКД-67-06/23	Хөвсгөл аймаг, Мөрөн сум Хөвсгөл Дэлгэрмөрөн Эрүүл мэндийн төв
			814,191,031.00			
НИЙТ ДҮН			(найман зуун арван дөрвөн сая нэг зуун ерэн нэгэн мянга гучин нэгэн төгрөг)			